

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

/2019 оны эхний хагас жилийн байдлаар/

2019.06.26

Дархан

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилт, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) –ийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” цэсэнд байршсан 57 зорилтын 93 арга хэмжээ, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нэгтгэсэн тайлан, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээллийг болон Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн нэмэлт мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

**2019 оноос хэрэгжүүлж эхлэх 2 зорилтын 2 арга хэмжээ цахим санд шинээр нэмэгдсэн байна. Үүнд:**

3.2.48.2 Улсын болон орон нутгийн 10 музейг стандартын шаардлага хангасан сан хөмрөгтэй болгох;

2.91.4 Цэвэрлэх байгууламжийн хяналтын лабораториудын тоног төхөөрөмжийг шинэчлэх, боловсон хүчнийг чадавхижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх;

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.4 дахь заалтын дагуу гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.


**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

2019 оны жилийн эхний хагас жилийн байдлаар Дархан-Уул аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон: Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын 19 зорилтын 30 арга хэмжээ, Нийгмийн бодлогын 12 зорилтын 16 арга хэмжээ, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 12 зорилтын 31 арга хэмжээ, Засаглалын бодлогын 5 зорилтын 7 арга хэмжээ, Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан 9 зорилтын 9 арга хэмжээ, нийт 57 зорилтын 93 арга хэмжээг хяналтанд авч, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж ажиллалаа.

2018 оны эхний хагас жилд хяналтад авсан зорилт, арга хэмжээний тоог 2019 оны эхний хагас жилд хяналтад авсан зорилт, арга хэмжээний тоотой харьцуулж хүснэгт, графикаар харуулбал:

Он	Зорилт	Арга хэмжээ
2018 оны эхний хагас жил	64	93
2019 оны эхний хагас жил	57	93
Зөрүү	-7	0

**Хяналтад авсан зорилт, арга хэмжээ**



### Гурав. Дүгнэлт

Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үнэлгээгээр 2019 оны эхний хагас жилийн байдлаар **63.86** хувийн хэрэгжилттэй **3.19** онооны үнэлгээтэй байна.

Холбогдох зохицуулах салбарын зорилт, арга хэмжээгээр харуулбал:

- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын 19 зорилтын 30 арга хэмжээ 63.33 % буюу 3.16 онооны,
- Нийгмийн бодлогын 12 зорилтын 16 арга хэмжээ 68.12 % буюу 3.40 онооны,
- Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 12 зорилтын 31 арга хэмжээ 61.03% буюу 3.05 онооны,
- Засаглалын бодлогын 5 зорилтын 7 арга хэмжээ 78.57% буюу 3.92 онооны
- Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан 9 зорилтын 9 арга хэмжээ 55.55% буюу 2.77 онооны үнэлгээтэй байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Бодлогоор, үүнээс				Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан	
			Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	Нийгмийн бодлого	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	Засаглалын бодлого		
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	<b>57</b>	<b>19</b>	<b>12</b>	<b>12</b>	<b>5</b>	<b>9</b>	
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	<b>93</b>	<b>30</b>	<b>16</b>	<b>31</b>	<b>7</b>	<b>9</b>	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	<b>19</b>	6	5	5	2	1
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	<b>40</b>	13	5	13	5	4
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40.0%	<b>23</b>	5	6	9	-	3
		Үр дүнгүй буюу 0.0%	<b>6</b>	3	-	2	-	1
		Үнэлэх боломжгүй	<b>5</b>	3	-	2	-	-
<b>Хэрэгжилтийн хувь, оноо</b>		<b>63.86.% буюу 3.19 оноо</b>	<b>63.33% буюу 3.16 оноо</b>	<b>68.12% буюу 3.40 оноо</b>	<b>61.03% буюу 3.05 оноо</b>	<b>78.57% буюу 3.92 оноо</b>	<b>55.55% буюу 2.77 оноо</b>	

2019 оны эхний хагас жилээр хяналтад авсан арга хэмжээний тоог бодлогоор нь 2018 оны эхний хагас жилийн хяналтад авсан тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал:

Бодлогоор /он	Нийт арга хэмжээ	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	Нийгмийн бодлого	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	Засаглалын бодлого	Аймаг, орон нутгийн талаар тусгайлан оруулсан
2018 оны эхний хагас жил	93	30	16	31	7	9
2019 оны эхний хагас жил	<b>93</b>	<b>30</b>	<b>16</b>	<b>31</b>	<b>7</b>	<b>9</b>
<b>Зөрүү</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Үндсэн хэрэгжүүлэх байгууллагаар нь харуулбал:

- Хууль, эрх зүйн хэлтсийн хүрээнд 3 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 70.0 % буюу 3.5 оноо,

- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд 29 зорилтын 60 арга хэмжээний хэрэгжилт 62.18% буюу 3.10 оноо,
- Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд 16 зорилтын 20 арга хэмжээний хэрэгжилт 75.0% буюу 3.75 оноо,
- Орон нутгийн өмчийн газрын хүрээнд 3 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 80.0% буюу 4.0 оноо,
- Захирагчийн албаны хүрээнд 5 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилт 51.66 % буюу 2.58 оноо,
- Мэдээлэл, технологийн албаны хүрээнд 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 100% буюу 5.0 онооны үзүүлэлттэй байна.

№	Хэрэгжилт	Бүгд	Хэрэгжүүлэх хэлтэс /агентлаг/, үүнээс						
			Хууль эрх зүйн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Нийгмийн бодлогын хэлтэс	Орон нутгийн өмчийн газар	Захирагчийн алба	Мэдээлэл технологийн алба	
1.	Хяналтанд авсан нийт зорилтын тоо	<b>57</b>	<b>3</b>	<b>29</b>	<b>16</b>	<b>3</b>	<b>5</b>	<b>1</b>	
2.	Хяналтанд авсан нийт арга хэмжээний тоо	<b>93</b>	<b>3</b>	<b>60</b>	<b>20</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>1</b>	
3.	Үүнээс	Үр дүнтэй буюу 100.0%	<b>19</b>	-	10	6	1	1	1
		Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70.0%	<b>40</b>	3	26	6	2	3	-
		Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40.0%	<b>23</b>	-	15	8	-	-	-
		Үр дүнгүй буюу 0.0%	<b>6</b>	-	4	-	-	2	-
		Үнэлэх боломжгүй	<b>5</b>	-	5	-	-	-	-
<b>Хэрэгжилтийн хувь, оноо</b>		<b>63.86% буюу 3.19 оноо</b>	<b>70.0% буюу 3.5 оноо</b>	<b>62.18% буюу 3.10 оноо</b>	<b>75.0% буюу 3.75 оноо</b>	<b>80.0% буюу 4.0 оноо</b>	<b>51.66% буюу 2.58 оноо</b>	<b>100% буюу 5.0 оноо</b>	

2019 оны эхний хагас жилд хэрэгжүүлэх нэгжээр хяналтад авсан арга хэмжээг, 2018 оны эхний хагас жилийн хяналтад авсан арга хэмжээтэй харьцуулж харуулбал:

Хугацаа	Нийт арга хэмжээний тоо	Хэрэгжүүлэх хэлтэс /агентлаг/, үүнээс						
		Хууль эрх зүйн хэлтэс	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Нийгмийн бодлогын хэлтэс	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Орон нутгийн өмчийн газар	Захирагчийн алба	Мэдээлэл технологийн алба
2018 оны эхний хагас жил он	93	2	58	20	1	3	7	2
2019 оны эхний хагас жил	<b>93</b>	<b>3</b>	<b>60</b>	<b>20</b>	-	<b>3</b>	<b>6</b>	<b>1</b>
Зөрүү	0	+1	+2	0	-1	0	-1	-1

Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 93 арга хэмжээний **63.44%** буюу **59** арга хэмжээний хэрэгжилтийг “**Хангалттай**” гэж үзэж байна.

***Хэрэгжилт сайтай, тодорхой үр дүнд хүрсэн, иргэдийн хүлээлттэй байгаа арга хэмжээнүүдээс дурдвал:***

**2.26.3** “Малжуулах” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх /ОНХС-150.0 сая төгрөгийн 100 хээлтэгч мал/,

**2.34.2** Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх техник, тоног төхөөрөмжийг сайжруулж, өвс, тэжээлийн агуулахыг орон нутагт бий болгох /Хонгор, Орхон, Шарын гол сум агуулах, савтай болоод байна. ОБЕГазарын 1 га газрыг аймгийн болон Дархан сумын нөөцийн өвс тэжээл бэлтгэн хадгалах газраар урт хугацаагаар гэрээ байгуулж ашиглахаар, 2018-2019 өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн аюулгүй нөөцөд өвс 30 тн, тэжээл 20 тн-ыг бэлтгэх ажлыг зохион байгуулж 100 хувь бэлтгэн аймгийн ОБГ-ын Улсын нөөцийн салбарт болон үйлдвэрийн зориулалтын агуулахад хадгалж байна/,

**2.39.7** Газар тариалангийн механикжсан ажлыг төлбөртэй гүйцэтгэж өгдөг аж ахуйн нэгж, хоршоонд техник, технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх, төмс хүнсний ногоо үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл хийх /24.5 сая ам. долларын хөрөнгөөр газар тариалангийн үйлдвэрлэлд нэн хэрэгцээтэй байгаа 50-165 м.х-тэй трактор 186 ширхэг, хадлангийн зориулалттай 40 иж бүрдэл техник, таримал тэжээл үйлдвэрлэлийн зориулалттай 20 иж бүрдэл техник, үр тариа, тэжээлийн таримлын 50-125 га талбайг услах 130 ширхэг бороожуулагч, төмс, хүнсний ногооны 1-10 га талбайг услах 116 ширхэг дунд болон бага оврын бороожуулагч, жимс, жимсгэнийг услах зориулалт бүхий 90 ширхэг дуслын усалгааны систем болон 110 мм-450 мм диаметр бүхий усалгааны хуванцар хоолой тус тус нийлүүлэгдэж, хөдөө аж ахуйн трактор, техник, хүнсний ногооны бага, дунд, том оврын бороожуулагч, тоног төхөөрөмж, усалгааны хоолой, дуслын усалгааны системийг тус тус зээлээр олгож байна/,

**2.93.1** Хөдөө орон нутгийн интернэтийн үйлчилгээ хүрээгүй сумд, стратегийн болон аялал жуулчлалын бүс нутаг, хүн ам ихээр төвлөрдөг газарт утасгүй интернэтийн үйлчилгээг хүргэх /Аймгийн 4 сум 26 багт интернэтийн үйлчилгээ үүрэн телефоны Мобиком, Юнител, Жи мобайл компаниудын өндөр хурдны 4G сүлжээний бүсэд бүрэн хамрагдсан. Дархан-Уул аймгийн Дархан 50 цогцолбор, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэн, их дээд сургууль, Олон улс, Бийрж, Номин зэрэг 6 томоохон худалдаа үйлчилгээний төвүүд болон гэр хорооллын захын бүсүүдэд Кевикогийн утасгүй интернэтийн бүс бүрэн үүссэнээр иргэд интернэтийн үйлчилгээг авах боломжтой болсон/,

**3.1.8.4** Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт эсэн мэнд амаржихуйн сургалтын нэгж байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах / шинээр баригдсан 50 ортой төрөх эмнэлэгт сургалтын нэгж, төслийн хүрээнд 45 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн хэрэглэгдэхүүнтэй “Эмнэл зүйн ур чадвар олгох сургалтын танхим”-тай болсон. Үүнд: зүрх амьсгалын сэхээн амьдруулах тусламжын тоног төхөөрөмж, төрсний дараах цус алдалтын үед тусламж үзүүлэх хэрэгслүүдтэй болсон/,

**3.2.2.2** Хөдөө орон нутагт малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгийн тоог өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх /нийт 5 гэр цэцэрлэгт 185 хүүхдийг гэр болон нүүдлийн цэцэрлэгт хамруулснаар 2018-2019 оны хичээлийн жилд малчин өрхийн 345 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулсан/,

**3.2.3.1** Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ /2018-2019 оны хичээлийн жилд аймгийн нийт ЕБС-даас 1 ээлжээр хичээллэдэг 16 сургууль, 2 ээлжээр хичээллэдэг 11 сургууль байна. 3 ээлжээр хичээллэдэг сургууль байхгүй/,

**3.4.2.5** “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг дэмжиж, хамгааллын тусламж шуурхай үзүүлэх түр хамгаалах байр байгуулах /198 удаагийн хамтарсан багийн хурлаар 161 хүүхэд, 216 насанд хүрэгч, нийт 377 хүнд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн нь 7,5 дахин өсч үйл ажиллагаа тогтмолжсон, Дархан сумын 16 өрхийн эрсдэлт нөхцөлд амьдарч буй 24 хүүхдийг шинээр илрүүлэн эрсдлийн программд бүртгэж, Түр хамгаалах байраар үйлчилгээ авсан 47 хүүхдээс 39 хүүхдийг хамтарсан багийн хяналтад өгч гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. 2019 онд 177 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, 10 удаагийн арга хэмжээ зохион байгуулан, 2 138 150 төгрөг зарцуулсан/,

**3.4.3.4** “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж /Дархан-Уул аймагт ТОСК-ийн 155 байрыг холбогдох журмын дагуу 155 айл түрээслэн амьдарч байна/,

**4.2.5.2** Усны хэрэглээг бүрэн тоолууржуулж, усыг хэмнэлттэй зарцуулах хэвшлийг бий болгох /2019 онд 200 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг тоолууржуулахаас эхний хагас жилийн байдлаар 179 айл өрх, 62 ААН аж ахуйн нэгж байгууллагыг тоолууржуулсан/,

**6.7.7.1** Төрөх эмнэлгийг шинээр барьж, нэгдсэн эмнэлгийн хашаан доторх замуудыг өргөтгөж сайжруулах / Эрүүл мэндийн яамны захиалгаар Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх эмнэлгийн барилгыг 2681,1 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэйгээр “Жи Жи Ай” ХХК барьж

ашиглалтад орсон. Нэгдсэн эмнэлгийн гадна талбайд 3\*2\*5 хэмжээтэй 8 машины авто зогсоол, хүлээн авах тасгийн үүдний хэсэгт 10 машины 20 м2 авто зогсоолыг байгуулж 2.032.8 сая төгрөг зарцуулсан/.

***ЗГХЭГ-ын даргын 2019 оны 05 сарын 31-ний өдрийн ХЭГ/1556 албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд дараах зорилт, арга хэмжээ эрчимжүүлэн тодорхой үр дүнд хүргэх шаардлагатай. Үүнд:***

4.1.6.5. Гэр хорооллын өрхийн ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох жишиг төсөл хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх. ***/ХОХБТХ, ЗА, БОАЖГ болон холбогдох агентлагууд/***

4.1.6.6. Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага MNS 5924:2015 стандартыг хэрэгжүүлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх. ***/ХОХБТХ, ЗА, БОАЖГ болон холбогдох агентлагууд/***

4.2.5.5. Гол мөрний хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, *хог хаягдлыг цэвэрлэх ажлыг тогтмол зохион байгуулж*, голын эргийн дагууд тохижуулж, иргэд амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх бүс болгон хөгжүүлэх.

***/Дархан сумын ЗДТГазар, ХОХБТХ, НБХ, БТСГазар болон холбогдох агентлагууд/***

6.7.4.1 “Багш хотхон” болон “Боловсрол хотхон”-ы бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ***/НБХ, БСУГ, ХОХБТХ болон бусад холбогдох агентлагууд/***

***2017, 2018 оны жилийн эцэс, 2019 оны эхний хагас жилийн үнэлгээгээр буюу 3 удаагийн үнэлгээгээр “үнэлэх боломжгүй” гэж үнэлэгдсэн 4 зорилт, 4 арга хэмжээг үргэлжлүүлэх эсэх саналыг Төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох байгууллагад бодлогын хэлтэс, холбогдох агентлагууд нь уламжилж ажиллах шаардлагатай. Үүнд:***

2.30.2 Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ/ стандарт шинэчлэн боловсруулагдаж, батлагдаагүй, ***/ХОХБТХ, ХХААГазар/***

2.89.1 Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах / Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх чиглэл орон нутагт ирээгүй байна/, ***/ЗА, НААҮГазар/***

4.2.2.1 Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, байгальд ээлтэй аялал жуулчлал, ногоон хөгжлийн түшиц газар болгон хөгжүүлнэ/ “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх чиглэл орон нутагт ирээгүй байна/, ***/ХОХБТХ, ГХБХБГазар/***

4.2.6.4 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ /“Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр”-ийн төсөл орон нутагт ирээгүй байна/, **/ХОХБТХ, БОАЖГазар/**

#### **Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх зөвлөмж**

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд:

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын баталсан “Зөвлөмж”-ийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 3.1 “...арга хэмжээ тус бүрийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийг эх үүсвэрийн хамт тодорхой тайлагнасан эсэх”,
2. Гурван удаагийн тайлагналтаар “Үнэлэх боломжгүй”-ээр үнэлэгдсэн арга хэмжээнүүдийг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар ХОХБТХэлтэс, ХХААГазар, ЗА, НААҮГазар, ГХБХБГазар, БОАЖГазрууд саналаа дээд шатны байгуулагуудад хүргүүлж шийдвэрлүүлэх, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний хүрээнд ХОХБТХэлтэс, НБХэлтэс, ЗА, Дархан сумын ЗДТГ болон бусад холбогдох агентлагууд удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах,
3. Зорилт, арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын талаар бүрэн тусгах, хүрсэн үр дүнг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах,
4. ЗГХЭГ-ын даргын 2019 оны ХЭГ/1556 албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 2019.06.14-ны өдрийн Мэдээллийн цагаар хүргэсэн зөвлөмжийг тус тус хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

С.НАСАНБАТ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

Д. ЖАРГАЛСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

О.МӨНХСҮРЭН



